

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 5 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар а/53

Бодь

ЦАГИЙН ХУВААРЬ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "ж", 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Суманд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа, үйлчилгээний газруудын цагийн хуваарийг хавсралтаар баталсугай.
- 2.Цагийн хуваарийг чанд мөрдөж ажиллахыг худалдаа, үйлчилгээний газруудад, ажиллах цагийн хуваарьт хяналт тавьж ажиллахыг хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч /М.Цэнд-Аюуш/, Бодь 5-р багийн Засаг дарга
/Б.Амармаа/ нарт тус тус үүрэг болгосугай.
- 3.Энэ захирамжийг Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр мөрдөж ажилласугай.
- 4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Н.Сумъяа/-д даалгасугай.

ДАРГА Р.БАТЖАРГАЛ